

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОЙРЫН ИРЭЭДҮЙН ДИНАМИК, СЭТГЭЛГЭЭНИЙ ПАРАДИГМЫГ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГУУД

Доктор (Sc.D), профессор Ц.Даваадорж (СЭЗДС)

Хураангуй

Монголын эдийн засаг эдүүгээ “нугарлын цэг”-ийн цаг үед тулж ирлээ. Нэлээд хэдэн жил үргэлжилсэн уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний дэлхийн үнийн өсөлтийн мөчлөг дуусч, бид нэн таатай нөхцлийг бүрэн, зөв ашиглаж чадсангүй, харин хямралт байдалд өртлөө.

Өнөөгийн энэ хямрал бидэнд үлэмжхэн ухаарал сургамж өгч цаашдаа гадаад эдийн засгийн харилцааг улам өргөжүүлэхийн зэрэгцээгээр эх орныхоо дотоод ресурс нөөцөнд улам илүү тулгуурлан өөдлөх өргөжих боломж, чиг хандлагыг тодорхойлж өгч байна. ухаарал, туршлагажилт ч өөрөө томоохон ресурс.

Дэлхий ертөнц даяар техник технологи үйлдвэрлэлийн шинэ IV хувьсгалыг угтан хүлээн авах бэлтгэл ажилдаа орж байна. Монголын ойрын ирээдүйн эдийн засгийн амьдрал энэхүү хандлага чиглэлийн хүрэн дотор түүний уур амьсгалаар үргэлжлэх төлөвтэй.

1. Монголын эдийн засгийн өнөөгийн тойм байдал

Монголын нийгэм эдийн засгийн нэн шинэхэн түүх эхлээд эдүүгээ 25 жил нь тохиож байна. Монгол орон 1990-ээд оны эхээр улс төрийн ардчилалд тулгуурласан нийгмийн шинэ байгуулал, эдийн засгийн хувьд зах зээлийн системд шилжиж буйгаа тунхагласан билээ. Өнгөрсөн энэхүү түүхэн богино хугацаанд монголын эдийн засаг өмнөх үеийн зогсонги байдал, шилжилтийн үеийн гүн хямрал, уналтаас гарч чадсан ба дараах мөчлөгүүдэд дахин уналт хямралт байдалтай тулгарч байсан боловч ойрын ирээдүйд зугуухан тэлж өсөх бааз сууриа бүрдүүлж амжих байхаа гэсэн ерөнхий дүгнэлт хийж болно.

Монголын эдийн засаг эдүүгээ 22 их наяд төгрөгөөр хэмжигдэх ДНБ-ний түвшинд хүрч 1990 оныхоос бараг 4 дахин тэлж өслөө. Энэ нь дэлхийн банкны тооцоогоор бол 12 тэрбум доллар, худалдан авах чадварын тооцоотой уялдуулан авч үзвэл бараг 25 тэрбум доллар болж байна. Гэхдээ энэ нь манай орны хувьд өөрийнхөө бүх боломж, потенциалгаа бүрэн ашиглаж хүрсэн дээд амжилт, үзүүлэлт бишээ. Монгол орон өчүүхэн бага цар хүрээтэй, үлэмжхэн онцлогтой эдийн

засагтай боловч дотоод потенциал, нөөц баялаг нь эдийн засгаа нэлээд өндөр түвшинд хүргэх боломжтой байсан. Өөрөөр хэлбэл бид гарааны үед монгол иргэдийнхээ асар их хүлээц, найдвар, үйл ажиллагааны идэвхжилийг зөв дэмжиж, хэрэгжүүлж, бүрэн ашиглаж чадсангүй.

Монголын нэн шинэхэн түүхийн энэ хугацаанд манай эдийн засаг хэвийн байдлаас хэтэрхий их савлагаа бүхий динамиктай байсан нь ажиглагдана. Энэ хугацаанд монголын эдийн засаг гурван томоохон хямралд өртөж байсан бөгөөд сүүлчийн хямралыг эдүүгээ бид нар бодит амьдралаараа мэдэрч байна.

Анхны хамгийн хүнд бөгөөд урт хугацааг хамарсан хямрал нь 1991-2000 оны эхний жилүүдийнх. Дараагийн хямрал нь 2008-2010 оных бөгөөд бараг 2 жил үргэлжилжээ. Энэхүү хямралын дараахан монголын эдийн засгийн гадаад орчин нэн таатай болж, олны дээдэлснээр “солонгорлын жилүүд” болж, эдийн засгийн тэлэлт, өсөлтийн савлагаа дээд цэгтээ хүрч байжээ. 3 дахь хямрал нь 2014 оноос өнөөдрийг хүртэл үргэлжилж байгаа орчин үеийнх.

Одоо монголын эдийн засгийн савлагааны доод цэгүүд буюу хямрал хүндрэлийн жилүүдийн онцлог байдал, учир шалтгааныг тодруулж тайлбарлая. Монголын эдийн засаг 1980-аад оны төгсгөл үед буюу социализмын задралын жилүүдэд зогсонги байдалд орсон бөгөөд зах зээлд хөл тавингуутаа шууд гүн хямралд өртөж, дөнгөж 2000-аад оны эхэнд буюу 10 жилийн дараа гарааныхаа түвшинд хүрсэн түүхтэй.

Монголын эдийн засгийн динамик (1991-2001 он)

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Жилийн өсөлт, бууралт (%)	-9,2	-9,5	-3,0	2,3	6,3	2,4	4,0	3,5	3,2	1,1	1,0
1990 оны ДНБ=100%	90,8	82,0	80,0	82,0	87,0	89,0	93,0	96,0	99,0	100,0	101,0
Төгрөгийн сулралт (%)	640	275	164	4,4	14	46	17	11	19	2,3	-
Инфляцийн нийт түвшин 1990=1,00	3,05	13,0	36,7	61,1	93,6	135,3	163,1	172,0	190,1	205,5	221,9

Статистик эмхэтгэл 1989-2002

Зах зээлийн эдийн засгийн анхны буюу гарааны үеийн хямрал нь бараа таваар үйлчилгээний онцгой хомсдол ба гадаад эдийн засгийн харилцааны огцом

хумилтаас үүсчээ. Тэр үеийн засгийн газар гадаад орчны сөрөг нөлөөллөөс шалтгаалан хомсдлын эдийн засгийн нөхцөлд төгрөгийн худалдан авах чадварыг засгийн газрын шийдвэрээр 1991 оны 1 сарын 17-нд хоёр дахин буулгасан билээ. Үүний дараахан Монголд 2 жилийн турш гиперинфляци үргэлжилсэн билээ. Гэхдээ 1991 онд хоёр шатлалтай банкны тогтолцоонд шилжиж, арилжааны банкуудтай болсон ба 1993 онд монголын шинэ мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулсан явдал санхүүгийн системийг тогтворжуулж, 1998 он гэхэд инфляцийн түвшинг жилд 6 хувь хүргэж багасгаж чаджээ. Энэхүү хямралын үеийн сүүлчийн жилүүдэд (1998-2000 он) цаг агаарын хүндрэлээс шалтгаалсан хөдөө аж ахуйн уналт болон гадаад худалдааны татвар эрс багассан нь монголын эдийн засгийг улам мөхөсдүүлжээ.

Монголын эдийн засгийн анхны энэхүү хямралт байдлаас гарахад өмч хувьчлалын тухай ерөнхий шийдвэр болон хөдөөгийн иргэд, малчдад мал сүргийг хувийн өмчинд үнэ төлбөргүй шилжүүлсэн зоримог шийдлүүд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Гэхдээ өмч хувьчлалын үндсэн зорилт, зарчмуудыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй, аж ахуйн томоохон нэгжүүдийг төрийн мэдэлд үлдээсэн зэрэг гажуудал дутагдал болон тэр үеийн сүүлчийн жилүүдийн нэлээд таатай гадаад орчин нөхцөлүүдийг бүрэн ашиглаж амжаагүй учир хямралт байдлыг хэтэрхий удаан үргэлжлүүлжээ. Нөгөө талаар энэ үеийн нэн хүнд хямралаас гарахад Монгол-Оросын хамтарсан үйлдвэр “Эрдэнэт” чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглүүштэй. Ер нь том төсөл, том үйлдвэрлэл ямар ач холбогдолтой байдгийг энх энэ үеэс ойлгосон байх учиртай юм.

Монголын эдийн засгийн дараагийн томоохон хямрал агуулсан мөчлөг нь 2000-аад оныг бараг бүхэлд нь буюу мөн 10 жил шахам хугацаа хамарчээ. Энэхүү мөчлөг зугуухан бөгөөд савлагаа багатай эдийн засгийн өсөлтөөр эхлэж, 2009 оны хямралаар дууссан билээ. Энэ мөчлөгийн үед монголын эдийн засгийн нийт өсөлт хамгийн өндөр түвшинд буюу 2002-2010 онуудад нийт дүндээ 76 хувиар өсчээ. Нөгөө талаар гиперинфляцийг зогсоож чадсан нь ард иргэдийн амьдралын түвшинд үлэмжхэн эерэг нөлөө үзүүлжээ.

Монголын эдийн засгийн динамик /гол үзүүлэлтүүд/
(2002-2010 он)

	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
ДНБ-ний жилийн цэвэр өсөлт, бууралт (%)	4,0	5,6	10,7	6,2	8,0	10,2	8,9	-1,3	6,1

Уул уурхайн салбарын өсөлт бууралт (%)	-8,2	-2,3	34,3	11,3	5,0	1,1	-1,6	5,8	6,3
Инфляцийн жилийн өсөлт (%)	1,6	4,7	11,0	9,5	4,3	2,6	28	8,0	10,1

Энэ үеийн эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн огцом тэлэлт байжээ. 2000-аад оны эхэнд уул уурхайн салбар ДНБ-ний үйлдвэрлэлд 10 орчим хувийг эзэлдэг байсан бол 2004 онд гэнэт 34 хувиар өсч ДНБ-ний үйлдвэрлэлийн 20 хувьд хүрсэн байна. Гэхдээ тун удалгүй 2008 онд дэлхийн эдийн засгийн хямралаас шалтгаалан монголын уул уурхай олборлох үйлдвэрлэл хумигдаж эхэлмэгц манай эдийн засаг дахин 2008, 2009 онд уналтанд автагдсан байдаг. Өөрөөр хэлбэл монголын эдийн засгийн савлагаа эхлэх гол нөхцөл, хүчин зүйл ингэж эхэлсэн ажээ. Нөгөө талаар манай уул уурхайн өсөлт, тэлэлт тодорхой бодлого зохицуулалтгүй байснаас шалтгаалан эдийн засгийн голланд өвчинд нэрвэгдэх нөхцөл байдлыг бүрдүүлсэн билээ.

Гуравдугаар буюу их савлагааны мөчлөг 2011 оны эдийн засгийн өндөр өсөлтөөс эхэлж 2-3 жилийн дараа хумигдаж буурах хандлагад шилжиж энэ 2016 онд доод цэгтээ хүрэх төлөвтэй байна.

Монголын эдийн засгийн динамик /гол үзүүлэлтүүд/

	2011	2012	2013	2014	2015
ДНБ-ий цэвэр өсөлт (%)	17,5	12,4	11,7	7,8	2,3
ДНБ (их наяд төг)	13,1	16,7	19,2	21,9	22,4
Гадаадын хөрөнгө оруулалт (тэрбум төг)	5554	5992	3201	923	460
ДНБ-нд ГХО-ын эзлэх хувь (%)	42,0	36,0	17,0	4,0	2,0

Статистикийн эмхэтгэлүүд

Энэ мөчлөгийн эхлэлийн үеийн эдийн засгийн өсөлт гадаад нэн таатай орчноос шалтгаалжээ. 2011 онд эрдэс түүхий эдийн дэлхийн зах зээл дээр нүүрс, зэсийн баяжмалын үнэ эрс өссөн ба нөгөө талаар үүнтэй холбоотой гадаадын хөрөнгө оруулалт мөн ихээхэн нэмэгджээ.

Энэхүү мөчлөгийн онцлог нь эдийн засгийн өсөлт - хумилтын савлагааны амплитуд нь үлэмжхэн хэмжээтэй байсанд оршино. Өмнөх жилүүдэд гүн хямралд орж ДНБ-ний хэмжээ 2009 онд өмнөх жилээс багасч (-1,3% хүртэл буурч) байсны дараахан гэнэт 2011 онд 17,5% өссөн үлэмжхэн хэмжээний савлагаа үүсчээ. Үүний шалтгааныг дээрх хүснэгтэнд харуулсан мэдээллээс харж болно. 2011 онд

ажиглагдсан монголын эдийн засгийн гэнэтийн өндөр өсөлт нь мега төсөл, ялангуяа Оюу толгойг ашиглах төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой ажээ. Гадаадын хөрөнгө оруулалт 2011 онд 4,7 тэрбум ам.доллар, 2012 онд 4,4 тэрбум ам.долларын цар хэмжээгээр манай эдийн засагт орж ДНБ-ний 42 хувьд хүрсэн ажээ.

Харамсалтай нь эдийн засгийн энэхүү боломжийг анхаарч ойлгоогүй тэр үеийн төрийн дээд удирдлагууд дээрх төслүүдийг зогсоох хүртэл <<зориглож>> чадсан билээ. Ингэж гадаадын хөрөнгө оруулагчдыг дүрвээснээс шалтгаалан монголын эдийн засаг энэхүү мөчлөгийнхөө хумилт, агшилтын үедээ хоёрхон жилийн дараа шилжижээ.

Монголын эдийн засгийн тэлэлт, агшилтын мөчлөг бүхэн ямар нэгэн онцлогтой бөгөөд зохих туршлага, сургамжийг бидэнд өгдөг. Энэ удаагийн мөчлөгөөс ажиглавал монголын жижиг эдийн засагт мега төслүүд ихээхэн ач холбогдолтой байдаг ба түүнд хүндэтгэлтэй, маш болгоомжтой, ухаалаг хандаж байхыг зөвлөж байх шиг. Ер нь манай эдийн засагт гадаад эдийн засгийн харилцааны огцом тэлэлт томоохон төслүүдийн хэрэгжилт эерэг ба сөрөг олон үр дагавартай байдгийг анзаарууштай.

Том төслүүд хэрэгжиж эхэлмэгц гадаад валютын урсгал өсдөг ба эхэн үедээ гадаад валютын нөөц эрс нэмэгдэж, улсын төсвийн зарлага ба импортын хэмжээ хэвийн байдлаас үлэмжхэн өсдөг жамтай ажээ. Эдгээрийн дараах шатанд инфляци, дотоодын үйлдвэрлэл өсдөг учир иргэдийн ажил эрхлэлтийн түвшин дээшилж, номинал цалин хөлс ч нэмэгддэг боловч дийлэнх хүн амын бодит амьдрал хуучин хэвэндээ хоцордог бас нэг жам ёс ажиглагдаж байна. Үүнийг тодорхой тоо баримтаар харуулбал: Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ ДНБ-ний 20 хувиас дээш гарсан цаг үед эдийн засгийн тэлэлтийн савлагаа 10 хувиас дээшилдэг ба улсын төсвийн зарлага бараг 40 хувьд дөхөж очдог байна. Эдийн засгийн өсөлт 17 хувь хүрсэн 2011 онд импортын хэмжээ өмнөх 2010 онд 3,2 тэрбум ам.доллар байснаа гэнэт 2 дахин өсч 6,6 тэрбум ам.долларт хүрч, бараг 2014 он хүртэл өндөр түвшиндээ үлджээ. Өөрөөр хэлбэл манай импорт эдийн засгийн тэлэлтэнд өндөр мэдрэмжтэй, дагалдан түргэн өсдөг, харин хумилт агшилтын үед цаг хугацааны асар их, бараг 3-4 жилийн хожимдолтойгоор багасдаг нь төлбөрийн балансанд хүндрэл учруулж, үндэсний валютын ханшийг хэт унагаж хямралыг гүнзгийрүүлэх гол шалтгаан болдог ажээ.

Нөгөө талаар том төслүүдийн хэрэгжилт элитийн ба далд эдийн засгийг тэтгэж өргөжүүлдэг жамтай ажээ. Өнөөдөр монголын элитийн эдийн засаг дотоод хуримтлалын гол эх үүсвэр болж байгаа боловч нийт өрх аж ахуйн эцсийн

хэрэглээний бүтцийг өрөөсгөл хэлбэртэй буюу ихэвчлэн импортод чиглэгдсэн хандлагатай болгодог ажээ.

ДНБ хуваарилалт, үндэсний хуримтлал, иргэдийн хэрэглээ

	2011	2012	2013	2014
ДНБ (тэрбум төг)	13173	16688	19174	21937
ДНБ-д цалингийн эзлэх хувь (%)	23,9	26,3	26,0	26,3
ДНБ-д үйл ажиллагааны ашгийн эзлэх хувь (%)	57,2	55,9	56,0	57,4
Иргэдийн хадгаламж (тэрбум төг)	2554	3815	4625	5226
Өрхийн нийт хэрэглээ (тэрбум төг)	6782	8848	10698	12777
Ажиллагчдын тоо (мянган хүн)	1033	1037	1056	1103

Нийт иргэдийн хэрэглээ өнөөдөр ДНБ-ний бараг 60% буюу 13 их наяд төгрөгийн түвшин хэмжээнд хүрчээ. Үүнээс цалин буюу цалинтай адилтгах орлого нь 6 их наяд буюу өөрөөр хэлбэл цалингаар амьдардаг хүмүүсийн оролцоо нийт иргэдийн хэрэглээний зөвхөн тал хагас нь болж байна.

Ийм нөхцөлд жирийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хөгжил дэвшлийн өвөрмөц концепци, үзэл баримтлал боловсруулах ажил нэн чухал.

Гадаад эдийн засгийн харилцааны огцом өргөжилт, том төслүүдийн хэрэгжилт үндэсний хуримтлалын боломж, потенциалыг нэмэгдүүлэх эерэг талтай. Харин сөрөг тал нь эдийн засгийн салбаруудын хоорондох тэнцвэрт байдлыг алдагдуулдаг. Бид цаашдаа макро эдийн засгийн тэнцвэрийг хангахын тулд хуримтлал, нөөцийн удирдлагыг сайжруулж, дотоодын ресурс нөөцөө зөв ашиглан экспортыг нэмэгдүүлэх, импорт орлуулах үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжихэд чиглэгдсэн бөгөөд эцсийн дүндээ макро эдийн засгийн нийт эрэлтийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал тавих шаардлагатай болжээ.

2. Монголын эдийн засгийн ойрын ирээдүйн динамик, сэтгэлгээний парадигмыг өөрчлөх шаардлагууд

Монголын эдийн засаг өнөөдөр нугарлын цэгтээ тулж ирээд байна. Харин монголын нийт иргэдийн хувьд бол туршлагажилт ухаарлын он жилүүд болох төлөвтэй. Монголын эдийн засгийн өнөөгийн тойм байдлын талаар дээр дурдсан ерөнхий дүгнэлтүүдээс үзвэл Монгол оронд ойрын ирээдүйд шинэ зорилтуудыг дэвшүүлж, шинэ алхам хийх гарааны нөхцөл бүрджээ гэж үзэж болмоор байна.

Өнөөгийн төр засаг “Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2016-2030 он)” хэмээх баримт бичиг батлаж хэрэгжүүлж эхэллээ. Нөгөө талаар глобал ертөнц даяар хөгжил дэвшлийн ээлжит “нугарлын цэг” буюу аж үйлдвэржилтийн дөрөвдүгээр хувьсгалын эхлэлийг угтах талаар бэлтгэл ажил, төлөвлөлт хийж байна.

Мөн манай хөрш зэргэлдээ том гүрнүүд ч ойрын ирээдүйнхээ тойм төлөвлөгөөг боловсруулжээ. Хятад улс ээлжит таван жилийнхээ төлөвлөгөөг баталж шинэ зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж эхэллээ. Нийт дэлхий даяар үүссэн шинэ зорилт дэвшүүлж, хэрэгжүүлэх уур амьсгалын дотор Монгол орныг ойрын ирээдүйд хөгжүүлэх зорилго нь дэлхий нийтийн хөгжил дэвшлийн ерөнхий чиг хандлагыг баримтлахын зэрэгцээгээр манай орны онцлог, үндэсний сонирхлыг харгалзсан бөгөөд юуны өмнө биелэх боломжтой байх явдал нэн чухал.

Өөрөөр хэлбэл дээхэн үед манай улс төрийн намуудын өөр хоорондоо уралдан, сэтгэлийн хөдөлгөөнд автагдан дэвшүүлж байсан, биелэх боломжгүй эдийн засгийн тэлэлт, өсөлтийн тоон үзүүлэлтэнд ихэвчлэн анхаарсан хоосон мөрөөдлөөс ангижрах цаг болжээ.

Монгол орны эдийн засгийн өнөөгийн хязгаарлагдмал потенциалыг ойрын ирээдүйд хямралаас бүрэн гарах савлага багатай тогтвортой, жигддүү өсөж, тэлэх боломжийг бүрдүүлэх, салбар хоорондын тэнцвэр алдагдсан байдлыг арилгах, хүртээмжтэй эдийн засгийг төлөвшүүлэх зэрэг чанарын эргэлтийн үлэмжхэн том зорилтын суурь бэлтгэлийг хангахад чиглүүлэх нь зүйтэй болов уу. Өөрөөр хэлбэл өсөлт, тэлэлтийн тоон үзүүлэлтийн зэрэгцээгээр чанарын өөрчлөлтөнд шилжих “нугарлын цэг”-ийн үе болох бизээ.

Энэ талаар хийх ажлыг эдийн засгийн сэтгэлгээний өнөөгийн парадигмыг өөрчлөх, шинэчлэхээс эхэлбэл зохистой. Эдүүгээ эдийн засгийн хөгжил дэвшлийг тодорхойлох, томъёолох гол үзүүлэлтүүд, параметрийн талаар нийгмийн давхаргуудын хооронд зөрүүтэй ойлголтууд үлэмжхэн байна.

Юуны өмнө эдийн засгийн хязгаарлагдмал потенциалтай манай орны хөгжил дэвшил ямагт шулуун динамикаар, өндөр хурдацаар явах ёстой гэдэг хүсэл фантазиас салмаар байна. Монголын эдийн засаг өөдлөх-уруудах буюу тэлэх-хямрах мөчлөгүүдтэй тулгардаг юм байна. Мөчлөгүүд доторх өсөлт, уруудалтын савлагааг багасгаж, ерөнхий дэвшлийн чиг хандлагыг дэмжих, баталгаажуулахын тулд эрсдлийн буюу тогтвортой хөгжлийн сантай болох шаардлага ажиглагдана. Нөгөө талаар эдийн засгийн өсөлтийн гол үзүүлэлтүүд Монгол иргэдийнхээ амьдралын түвшинг тууштай дээшлүүлэх зорилтонд чиглэгдсэн бөгөөд үүнтэй нягт уялдсан хөгжлийн шинэлэг загварыг боловсруулах шаардлагатай болжээ. Энэ

талаар улс нийт даяар ижил төстэй агуулгатай болговол зохистой асуудлууд үлэмжхэн хуримтлагджээ. Жишээлбэл: ядуучууд, дундчууд хэмээх нийгмийн давхаргуудын талаарх ойлголт, үзүүлэлтүүдийг нийгмийн тохиролцоо, зөвшилцлийн хэлбэрээр боловсруулж, тодруулах нь хойшлуулшгүй зорилго мөн.

Мөн үндэстний хөрөнгөтөн, гадаадын хөрөнгө оруулагч нарын талаар төлөвшсөн үзэн ядах агуулгатай элдэв төрлийн муучлал, цуурхалаас салах цаг болжээ.

Эдүүгээ Монголын эдийн засагт гадаадынхны хөрөнгө активууд, дотоодын буюу үндэсний хөрөнгө баялагтай хүмүүсийн гэр аж ахуй, тэдний том бизнес нийлээд элитийн эдийн засгийг төлөвшүүлжээ. Энэ бол сайнтай, муутай бодит амьдрал. Энэхүү эдийн засаг өнөөгийн манай орны техник технологийн дэвшил, амьдралын шинэ хэв маягийн түлхүүр хүчин, үндэсний хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр болж эхэллээ.

Ер нь өнөөдрийн нийгмийн сэтгэлгээгээр бол хөгжил дэвшлийг зөвхөн эдийн засгийн өндөр өсөлт, үрэлгэн хэрэглээгээр төсөөлөх, ялангуяа ДНБ-ний өсөлтөөр төлөөлүүлэн, эдийн засгийн гол үйл ажиллагаа болон бусад зорилгоо түүнд нийцүүлдэг ажил зуршил төлөвшжээ. Монголын өнөөгийн нөхцөл байдалд энэхүү ойлголт, сэтгэлгээ ерөнхий хандлагын хувьд зөв зүйтэй боловч зөвхөн энэ үзүүлэлтэнд тулгуурлан цаашид хөгжих боломж хомс болсныг манай нэн шинэхэн түүхийн үеийн бодит амьдрал тодхон харуулж байна. Өнгөрсөн жилүүдийн эдийн засгийн динамикийг судалж үзвэл өндөр өсөлтийн дараа ямагт хямралт байдалд ордог жам ёс ажиглагдана. Энэ нь гуравхан удаагийн бөгөөд тохиолдлын чанартай үзэгдэл, хандлага бишээ.

Манай эдийн засгийн онцлог, өнөөгийн макро эдийн засгийн бүтэц, салбаруудын хоорондын харилцаа, харилцан хамаарал хэрвээ зөв зохицуулалт менежментээр хангаж чадахгүй урсгалаар нь хөвүүлж орхивол <Хямрал-өсөлт-хямрал> гэсэн богино хугацааны мөчлөгүүдийг буй болгож, дорвитой урагшлуулж, өөдлүүлдэггүйг анзаарцгаая. Үүнд: Хамгийн гол нь зөв зохицуулалт, үр дүнтэй менежмент гэдгийг өнөөгийн Монголчууд бидний өөрсдөө зохиосон, өөртөө тааруулсан “орон нутгийн” дүрэм журам хэлбэрээр биш цаашдаа дэлхий нийтийн баримталж буй олон улсын институцийн ба бизнес эрхлэлтийн норм дүрмийн дагуу эдийн засгаа хөтөлнө гэж ойлгох ёстой байх аа.

Эдүүгээ элитийн эдийн засаг, далд эдийн засаг, жирийн иргэдийн эдийн засгийн хоорондын уялдаа, харилцан хамаарлын асуудал бүр ч төвөгтэй, эмзэг бөгөөд зөв шийдвэрлэж чадахгүй бол үлэмжхэн сөрөг нөлөөтэй болж нийгмийн харилцаанд сөрөг нөлөөлөх эрсдэлтэй болж байгааг анзаармаар болжээ.

Монголын эдийн засгийн сүүлчийн (2010-2015 оны) өсөлт-хямралын мөчлөгөөс үзвэл манай эдийн засаг эдүүгээ хэрэгжиж буй том төслүүдээ цаашид үргэлжлүүлэх болон үндэснийхээ үйлдвэрлэлийг өргөтгөх, тэлэх бодлогоо эрчимжүүлж чадвал ойрын ирээдүйд (2020 он) хямралаас бүрэн гарч, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн суурийг тавьж амжина.

Хэдийгээр өнөөдөр манай эдийн засаг хямралт байдалд орсон боловч 2013-2015 онд экспортын чиглэлтэй ба импорт орлуулах дотоодын үйлдвэрлэл нэлээд эрчимтэй сэргэж, нийт ажиллагчдын тоо 70 орчим мянган хүнээр нэмэгджээ. Дашрамд дурьдахад том төслүүд ажил эрхлэлтийн түвшинд дорвитой эерэг нөлөө үзүүлдэггүй болохыг мөн ажиглаж болно.

Энэ үеийн хямралт байдлыг зөөлрүүлэхэд барилгын салбарыг тэлэх болон орон сууцжуулах бодлого, хөтөлбөр үлэмжхэн эерэг нөлөө үзүүлсэн. ДНБ-нд барилгын салбарын эзлэх хувийн жин 2011-2014 онд бараг 2 дахин нэмэгдэж, ажиллагчдын тоо мөн 2 дахин өсч 2015 оны эцэст бараг 100 мянган хүнтэй болжээ. Гэхдээ барилгын салбарын өсөлтөнд ипотекийн үлэмжхэн зээл нөлөөлж байгаа тул цаашид, энэ арга зам нэлээд эрсдэлтэй болохыг тэмдэглэх нь зүйн хэрэг. Нөгөө талаар орон сууцны эрэлтийг моргейжийн зээлээр хэт хөөрөгдөж байгаа сөрөг үзэгдэл ч анзаарагдаж эхэллээ. Энэ байдлаас болж макро эдийн засгийн нийт эрэлтийн бүтцэд барилга, барилгын материалын ердийн бус хөөсөрсөн эрэлт түр зуурын хугацаанд гарч, цаашдаа хумигдаж, барилгын салбар, барилгын үндэсний компаниудыг хямралд оруулж болзошгүй. Өөрөөр хэлбэл үлэмжхэн аюултай бүтцийн хямрал нүүрлэж магадгүй.

Монголын эдийн засгийн тогтвортой хөгжлийн концепцид хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуй томоохон байр суурь эзэлнэ.

Манай хөдөө аж ахуй бол хүртээмжийн үзүүлэлт параметруудаар хамгийн өндөр, ойрын ирээдүйд ч үлэмжхэн ач холбогдолтой салбар. Мал аж ахуй хамгийн бага хөрөнгө оруулалт шаарддаг бөгөөд хамгийн олон ажиллагчидтай, нийт улс орны хүнсний аюулгүй байдлыг ерөнхийдөө хангадаг. Ойрын ирээдүйд мал аж ахуй экспортын нэлээд дорвитой эх үүсвэр болохыг ч үгүйсгэх аргагүй. Гэхдээ Монголын мал аж ахуйд ч хөдөөгийн малчдын дунд орлого баялагийн ялгарал бас нэмэгдэх хандлагатай болсон ба уг аж ахуй маань байгаль цаг уураас хамааран өсөлт уруудалтын мөчлөгтэй байдгийг мартаж болохгүй. Өнөөдөр мал сүргийн бараг 50 хувийг нийт малчин өрхийн 17 хувь нь эзэмшиж байна. 50-иас доош мал сүрэгтэй буюу ядуурлын түвшинд амьдарч байгаа хөдөөгийн 20 мянга шахам малчин өрх байна. Ган, зуд болоход эдгээр хүмүүс ядууралд нэрвэгдэх өндөр

эрсдэлтэй учраас хөдөө аж ахуйд ч тогтвортой амьдралын тусгай, өвөрмөц хөтөлбөр боловсруулж, орон нутагт эрсдлийн сан байгуулах шаардлага гарч байна.

Монголын эдийн засгийн ойрын ирээдүйн үндэсний томоохон хөтөлбөрүүдийн хүрээнд дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангах, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах зэрэг төслүүд хэрэгжих бүрэн боломжтой бөгөөд эдийн засгийн өсөлт-хямралын савалгааг багасгахад шийдвэрлэх ач холбогдолтой. Шатахуун түлшний үндэсний үйлдвэрлэлтэй болж, өнөөгийн жижиглэн худалдаалах үнийг хямдруулбал бусад бараг бүх дотоодын барааны үнийг мөн хямдруулах учир Монгол иргэдийн гэр бүлийн төсвийн хэмнэлтэнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх ба инфляцийг хязгаарлах чухал нөхцөл бүрдэнэ.

Нөгөө талаар манай эдийн засагт байр сууриа нэгэнт олж бэхжсэн уул уурхайн салбараа өнөөгийн хурдац, далайцаар цаашид өргөжүүлж, гадаад валютын урсгалыг тэтгэхэд ашиглах шаардлагатай нь ойлгомжтой.

Монголын эдийн засгийн нийт нийлүүлэлттэй холбогдолтой чухал зорилгууд ийнхүү биелэх бүрэн боломжтой бөгөөд эдийн засгийн өсөлтийг 2017-2020 онд жилд дунджаар 5-7 хувьд хүргэх магадлалтай. Гэхдээ 2017 оноос эхлэх Монголын төрийн ба бизнес секторын нийт зээл, өрийн төлбөр манай эдийн засгийг хүндрүүлэх магадлалтай тул төлбөрийг дахин шилжүүлэх, хойшлуулах зэрэг арга хэмжээнүүдийг хугацаа алдалгүй эртнээс бэлтгэх нь чухал. Монголын эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд тусгагдсан бөгөөд улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг хамтруулан шийдвэрлэх ёстой томоохон зорилго бол Монгол иргэдийн амьдралын бодит түвшинг дорвитой дээшлүүлэх, нийгмийн дундаж давхаргыг төлөвшүүлж бүрдүүлэх зэрэг тодорхой тоо үзүүлэлтээр илэрхийлэгдсэн зоримог эрмэлзэл байгаа.

Өнөөдөр үндэсний тооцоондоо бид ДНБ хэмээх эдийн засгийн ерөнхий цар хүрээ, потенциалыг илэрхийлэх үзүүлэлтийг ашиглаж байна. Харин 1 хүнд ногдох ДНБ гэдэг үзүүлэлт бол хэтэрхий хийсвэр, чухам юуг илэрхийлж байгаа нь үл ойлгогдох, ялангуяа иргэдийн амьдралын түвшинг илэрхийлэх чадваргүй тоон мэдээлэл болж хувирчээ. Хэрэв өнөөдрийн энэ үзүүлэлтээр хүн бүрт жилд 8 сая төгрөг, гэр бүлдээ 3,6 хүнтэй Монгол айл бүрт 29 сая төгрөг ногддог байсан бол иргэдийнхээ амьдралыг “ядууралд” ороод байна гэж ярих ямар тэнэг хүн олдох вэ?

Гэтэл ядуурал байгаа нь үнэн бөгөөд дээрх баримт бичигт ядуурлыг ойрын ирээдүйд (2016-2020 он) 18 хувьд хүргэж доошлуулах ба хэтийн ирээдүйд дундчуудыг 80%-д хүргэнэ гэж тусгагджээ.

Үүнтэй холбогдуулан дурьдахад сэтгэлгээнийхээ парадигмыг өөрчилж 1 хүнд ногдох ДНБ-ний хэмжээ гэдгийн зэрэгцээгээр ядахдаа ядуу зүдүү байна гэдгийг зөв харуулах тодорхой үзүүлэлтийг нэмж ашигламаар байна.

Хөгжингүй орнуудын эдийн засгийн судалгааны материалуудад сүүлийн жилүүдэд медиан ба хүн амын (нийт өрхийн) суурь, доод хэсгийн дундаж орлого хэмээх үзүүлэлтүүд тусгагдсан байдаг. Энэ үзүүлэлт манай орны иргэдийн бодит амьдралын түвшинг арай тодорхой, ойлгомжтой харуулах чадвартай. 2013 оны байдлаар Монголын 800 мянга орчим өрхийн медиан буюу тэн хагасын 400 мянга дахь өрхийн сарын дундаж орлого 800 мянга орчим төгрөг ба жилийнх нь 10 сая төгрөгөөр илэрхийлэгджээ. Үүнээс үндэслэн тооцвол медиан өрхийн 1 хүнд ногдох жилийн орлого 2,8 сая төгрөг болно. Өөрөөр хэлбэл энэ үзүүлэлт 1 хүнд ногдох ДНБ-ний 8 сая төгрөг гэдгээс бараг 3 дахин бага бөгөөд амьдралын түвшин нь ядруухан талдаа байна гэдгийг харуулна.

Нөгөө талаар ядуурлын түвшингөөс доош нөхцөлд амьдарч буй иргэдийнхээ тоог статистик мэдээлэлд нийтэлж, төр засгийн удирдлагууддаа сануулж, анхаарлыг нь хандуулж баймаар юм.


Сүүлийн нэн төвөгтэй асуудал бол Монгол иргэдийн эдүүгээгийн тааруухан амьдралыг дэлхийн жишигийн дундчуудын түвшинд хэрхэн яаж хүргэх вэ? гэдэг тодорхой арга зам, шийдлийг томъёолох явдал. Үүнд: Өнөөдөр манай орны хувьд бол хариулт, шийдэл хараахан олдоогүй бөгөөд нугарлын буюу ухаарлын цэгийн он жилүүдэд (2016-2020 он) хямралыг даван туулах явцад бодит амьдрал өөрөө ямар нэг хувилбарыг дэвшүүлж анхааруулах бизээ.

Энэ асуудал бол зөвхөн Монгол орных, биднийх төдий бишээ. Дэлхийн бүх орнуудын улс төрийн дээд удирдлагуудын санааг зовоож байгаа толгойн өвчин бол нийт иргэдийн өчүүхэн бага хэсэг нь хэт баяжиж, нөгөө дийлэнх хэсэг нь улам ядуурч, эсвэл хэвэндээ хоцорч байгаа эрс зөрүүг хэрхэн яаж арилгах, дундчуудаа яаж хамгаалж, хадгалж үлдэх вэ? гэдэг арга замыг сүвэгчилж олох асуудал. Жишээлбэл: дэлхийн хамгийн хүчирхэг, хамгийн баян Америкт Жини коэффициент тасралтгүй өсөх хандлагатай болжээ. Энэхүү коэффициент 1970 онд 0,39 орчим байсан бол 2010 онд 0,47 болж өсчээ. 2013 онд нийт 138 сая ажиллагчдын хувийн орлого 9 их наяд долларт (ДНБ-ний 50%) хүрсэн бөгөөд үүнээс хамгийн өндөр орлоготой 1 хувь иргэдийн орлого 1,7 их наяд доллар болж доод 50 хувь буюу бараг 70 сая иргэдийн орлого нь нийт дүндээ 1 их наяд доллар болжээ. Өөрөөр хэлбэл дээд 1 хувь иргэдийн орлого нь доод 50 хувь иргэдийн бүгдийн орлогоос 1,7 дахин их гэсэн үг. Гэтэл 1980 онд ийм зөрүү байгаагүй ажээ. 1980 онд Америк иргэдийн дээд 1% нь 138 тэрбум доллар, доод 50 хувь нь 288 тэрбум долларын

орлоготой байжээ. Өөрөөр хэлбэл доод 50 хувийн нийт орлого нь илүү байж. Харин 33 жилийн дараа нөхцөл байдал эсрэгээр эргэсэн байна. Америкийн засаг захиргаа энэ байдлыг ажиглаж сүүлийн жилүүдэд чинээлэг хүмүүсийн татварыг нэмж тэдний орлогын өсөлтийг хязгаарлах арга хэмжээ авсан боловч үлэмжхэн өөрчлөлт гарсангүй. Америкийн нийгмийн амьдралын нэгэн эерэг онцлог нь гэвэл доод 50 хувийн иргэдийн орлого нь байнга өсч, амьдралын түвшин нь ямагт дээшилж байдагт оршино. Дээрхи мэдээлэлээс үзвэл доод 50 хувийн хүмүүсийн дундаж орлого 1980-2013 онд бараг 2,5 дахин өссөн байна.

Манай хөрш зэргэлдээ агуу том Хятад гүрэн ч иймэрхүү нөхцөл байдалтай тулгараад байх шиг. Дээхэн үед бүх нийтээрээ доохно түвшинд тэгшдүү байсан Хятад иргэд өнөөдөр баян, ядуугийн ялгаралд бас өртөөд байна. 1980 онд Хятадад Жини коэффициент 0,28 байсан бол 2010 оны байдлаар 0,52-т хүрчээ. Яагаад ийм хандлага чиглэл, жам зүй, бараг эдийн засгийн зарчим болдог вэ? Үүний хариулт нь эдүүгээгийн дээд техник технологид тулгуурласан эдийн засгийн өсөлтийн жам ёс ажээ.

Томоохон капитал, хөрөнгө, санхүүгийн баялгийн орчил эргэлт ба эдийн засаг, нийгмийн ач холбогдол



Ингэж эдийн засгийн өсөлтөнд том үйлдвэрлэл, шинэ техник технологи эерэг нөлөө үзүүлдэг боловч, хөрөнгө баялгийг хэт төвлөрүүлэх хандлага, чиглэл нь яваандаа улс төр, нийгмийг эрсдэлт байдалд хүргэдэг жам ёс тогтсон юм шиг харагдана.

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал ч энэ байдлаас аврах гарц биш. Харин ч улам түргэн гүнзгийрүүлэх хүчин зүйл болж хувирах төлөвтэй. Бүх дэлхийн улс гүрэн өнөөгийн хүмүүн төрөлхтний хамгийн гол “толгойн өвчин” бол хөрөнгө баялгийн тэгш бус байдал бөгөөд тэр нь аюулын түвшинд ойртсон явдал. Үүний шийдэл нь улс төр, нийгмийн хүрээнд байгаа бөгөөд улс төрийн зүтгэлтэн, төрийн түшмэдүүд, бизнесийн төлөөлөгчдийн ёс суртахуун, ухамсрын түвшингээс шалтгаалах төлөвтэй. Саяхан Америкийн Нью-Йоркийн саятнууд хотын захирагчдаа хандаж: “Бид татвараа нэмж төлье” гэсэн хүмүүнлэг санал дэвшүүлжээ. Энэ бол нэг шийдэл, амьдрал бусад хэлбэрийг яваандаа тодруулж өгөх биз.

Манай орны хувьд бол тэгш бус байдлыг арилгах гол гарц бол институцийн хүрээнд зоримог шийдэл гаргах явдал байх аа.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, 2016 он III Сар
2. Ч.Сайханбилэг. Монголын эдийн засгийн форум дээр хэлсэн үг 2016 он, IV сар
3. Монгол банк. Судалгааны ажил, УБ хот 2002 он
4. А.Волков. Журнал “Знание-сила”, стр 7. Март, 2016
5. Scott Greenberg. Summary of the Latest Federal income Tax Data, 2015 update. Tax foundation. Fiscal fact Nov, 2015. №491
6. Статистикийн эмхэтгэл. Монгол улс 100 жилд
7. Статистикийн эмхэтгэл “Монгол улс зах зээлд”
8. Статистик эмхэтгэлүүд 2013, 2014 он